

Үг нийлэх аргаар үг бүтэх

НИЙЛМЭЛ ҮГИЙН ТУХАЙ

Нийлмэл үг

Хоёр бие даасан үг зэрэгцэх ба угсрах харьцаагаар нийлж үг бүтээх аргыг үг нийлэх арга гэдэг. Энэ аргаар бүтсэн үгийг нийлмэл үг гэнэ.

Жнь: үр дүн, нялх балчир, ганц нэг, хожим хойно, шахаж шаард, хонин гүрвэл, эдийн засаг, хар хээр, шар цоохор, зохион байгуул ГЭХ МЭТ.

Нийлмэл үгийг
харьцаагаар нь

Зэрэгцсэн
нийлмэл үг

Угсарсан
нийлмэл үг

Зэрэгцсэн нийлмэл үг

ХОЁР ҮГ ХАРИЛЦАН ТЭГШ ЭРХТЭЙГЭЭР
НИЙЛЖ БҮТСЭН ҮГИЙГ ЗЭРЭГЦСЭН
НИЙЛМЭЛ ҮГ /ЗЭРЭГЦЭЭ ҮГ/ ГЭНЭ.

ЖНЬ: ЭРХ ЧӨЛӨӨ, ЭВ ЭЕ, ЭРХ ТАХИ,
ЭЛБЭГ ДЭЛБЭГ, УЙЛЖ УНЖ, ХАРЖ ХАНД

Угсарсан нийлмэл үг

ХОЁР ҮГ НЭГ НЬ НӨГӨӨДӨӨ УГСРАН
ЗАХИРАГДАЖ БҮТСЭН ҮГИЙГ УГСАРСАН
НИЙЛМЭЛ ҮГ / УГСРАА ҮГ /ГЭНЭ.

ЖНЬ:УСАН ҮЗЭМ, АЛТАН ХАРААЦАЙ,
ЭДИЙН ЗАСАГ,ХАР ХАЛЗАН, ЗҮҮН УРД,
БУТ НИРГЭ, БҮТЭН БОСГО, ГУЧИН ЗУРГАА
, АРВАН ДОЛОО

Угсарсан нийлмэл үг

Хамжиж угсарсан нийлмэл үг

Хамжиж угсарсан нийлмэл үгийн эхний үг нь дараагийнхаа үгэнд үндсээрээ угсарч холбогддог.

Жнь: морин шарилж, тэмээн хяруул, үхэр буу, ямаан арц, хээр алаг, улаан буурал, зүүн урд, огло харай, хонин гүрвэл

Найрч угсарсан нийлмэл үг

Найрч угсарсан нийлмэл үгийн эхний үг нь дараагийнхаа үгэнд нэрийн тийн ялгал, үйлийн холбох нөхцөлөөр угсарч холбогддог.

Жишээ нь : шинжлэх ухаан, номын сан, дүрслэх урлаг, тавны гурав, хэвлэн нийтэл, нөгөөдрийн маргааш, зохион байгуул:

Дараах үгсийг зэрэгцээ үг, угсраа үгээр ялган бичээрэй.

Мөнгөн ус, тэмээн хяруул, аз жаргал, эрх чөлөө, ашиг шим, аз жаргал, ард түмэн, санаа сэтгэл, эв эе, алтан хараацай, цагаан сар, улаан зээрд, бор алаг, эрт орой, өдий төдий, энд тэнд, хожим хойно, хар хөх, цагаан цэнхэр, ах дүү, амраг садан, алс хол

| Зэрэгцээ үг | Угсраа үг |
|-------------|-----------|
| | |